

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ ОНОШИЛГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ч.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2020.04.24 № 06/1311
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлан дэлгэрэнгүй бүртгэлээс 28.2 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.
- Төслийн нэгж урсгал зардлын төсвөөс хөрөнгө бэлтгэж, өглөг үүсгэсэн нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, үнэлгээ, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 –д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ч.Бат-Эрдэнэ Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл маягыг баталсан аргачлалын дагуу хөтөлж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 18-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Латана-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний Аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүн амын өсөлттэй холбогдон гарч буй бодит эрэлтэд тулгуурлан олон нийтэд эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээ, оношилгооны боломжит, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх, гадаадад эмчлүүлэхээр явж буй эмчлүүлэгчийн тоо болон эрүүл мэндийн нийт зардлыг бууруулах, орон нутгийн болон эрүүл мэндийн үйлчилгээ дутагдалтай газар илүү хүртээмжтэй эрүүл мэндийн онцгой, үйлчилгээг буй болгох оношилгооны алдаанаас үүдэн гарах нас баралтын хэмжээг бууруулахад оршино.

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төслийн хүрээнд орчин үеийн шаардлага, стандартад нийцсэн Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн үндсэн 103 ортой, 15,280 м2 талбайтай, зоорийн давхартай нийлээд 5 давхар барилга болон туслах барилга байгууламжууд, тэдгээрийн гадна шугам сүлжээ, зам талбай, тохижилтыг бүтээн байгуулна. Зээлийн гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газар тус эмнэлгийн дэд бүтэц, гадна шугам сүлжээ зэргийг хариуцаж хийх
- Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн бодлогын хүрээнд “Үндэсний оношилгоо, эмчилгээний төв”-д өндөр хүчин чадалтай, орчин үеийн дэвшилтэт эмнэлгийн тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад оруулна. Үүнд: 233 нэр төрлийн тоног төхөөрөмж болон эмнэлгийн багаж хэрэгсэл нийлүүлэгдэнэ. Мөн Монгол Улсад анх удаа эмнэлгийн зориулалттай цөмийн шугаман хурдасгуур буюу изотопын бэсрэг үйлдвэрийг суурилуулна.
- Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн болон нэгдсэн эмнэлгүүдэд зайн оношилгооны системийг, 5 бүсийн оношилгоо эмчилгээний төвд зайн оношилгооны тусгай зориулалт бүхий автомашин болон зайн оношилгооны системийг нийлүүлэх бөгөөд зайн оношилгооны систем суурилагдаж эмнэлгүүд хоорондоо холбоотой ажиллах.

Тайлант хугацаанд Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн дугаар 001 актаар барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн өмнөх тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын нийт дүн 40,857,600.4 мянган төгрөгөөс тооцон 408,576.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 26,136.4 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн 93.6 хувиар буурсантай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн 90,927,203.8 мянган төгрөгөөр буюу 5.4 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс урьдчилгаа болон үндсэн хөрөнгө дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,529,864.0	1,190,756.0	(339,108.0)
Урьдчилгаа	19,082,243.0	-	(19,082,243.0)
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	26,418.9	110,374,973.7	110,348,554.8
Нийт хөрөнгө	20,638,525.9	111,565,729.7	90,927,203.8
Өр төлбөр	5,905.9	1,190,994.3	1,185,088.4
Засгийн газрын оролцоо	20,632,620.0	110,374,735.4	89,742,115.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20,638,525.9	111,565,729.7	90,927,203.8

Авлага дансны үлдэгдэл буурсан нь татаас санхүүжилтийн авлага 339,108.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд татаас санхүүжилтийн 1,190,755.9 мянган төгрөгийн авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 110,348,554.8 мянган төгрөгөөр өссөн нь 2014-2018 онуудад тус төслийн хүрээнд гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжсэн 87,635,826.2 мянган төгрөгийн хөрөнгийг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын нэгтгэл тайланг бэлтгэх чиглэлийн дагуу балансад шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,190,994.3 мянган төгрөг байгаа нь цалингийн өглөг 238.2 мянга, 1,190,755.9 мянган төгрөг нь нэр бүхий 5 компанитай холбоотой байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 90,927,203.8 мянган төгрөгөөр өссөн нь балансад шилжүүлж авсан дээрх хөрөнгөөс гадна Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 21-д Сангийн сайдын зарцуулах багцад гадаад зээл, тусламжаас санхүүжих зардалд батлагдаж төслийн нэгжид тайлагнах болсонтой холбоотойгоор тайлант оны үр дүн 22,718,396.2 мянган төгрөг болсонтой холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээнд зориулан нийт 1,633,700.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ. Тайлант хугацаанд санхүүжилтийг бүрэн авч 605,593.3 мянган төгрөгийг зарцуулж 1,028,106.7 мянган төгрөгийг дутуу зарцуулсан ба өмнөх оны санхүүжилтийн авлага 976,392.5 мянган төгрөгийг авч нийт 2,004,499.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,028,357.5 мянган төгрөгөөр дутуу буюу 37.1 хувьтай байгаа нь эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 786,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 148,259.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь голлон нөлөөлжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэлд горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 90,571,122.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 89,298,740.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,272,382.6 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тухайн төсвийн жилд нь зарцуулаагүй буцаан төвлөрүүлж, Сангийн яамнаас авах авлагаар бүртгэсэн 1,190,756.0 мянган төгрөгийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

Үүнийг Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар онцгойлон анхаарч үзэх нь чухал байна.

Түүнчлэн төслийн хэрэгжих хугацаа дууссан ч төслийн хэрэгжилт 81 хувьтай байгаа нь анхаарал татаж байна. Иймд уг төслийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл нь Шилэн дансанд байршуулах 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн 2 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Цалингийн тооцооны хүснэгтээр 53,405.5 мянган төгрөгийн НДШ-ийг тооцсон боловч өглөгийг тайлагнаагүй. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягыг хөтлөх аргачлал хавсралтын 6.5.1."Ажиллагчдын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэл ЦХ-1"... *ажиллагсдын үндсэн цалин, нэмэгдэл цалин (зэрэг дэвийн нэмэгдэл, илүү цаг, удаан жилийн нэмэгдэл гэх мэт) болон олгохоор тооцсон цалинг бүртгэнэ. Олгохоор тооцсон цалин хөлсний дүнг цалингийн өглөг дансны кредитэд бичнэ.*" заалтыг хэрэгжүүлээгүй.

1.2 Эрсдэл:

Цалингийн зардлыг зохих журмын дагуу бүртгэж тайлагнаагүй байх, хууль, журам хэрэгжихгүй байх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн дагуу журналд бичилт хийж байх, Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу нягтлан бодох бүртгэлийн маягыг хөтлөх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгчийн зүгээс төсвийн гүйцэтгэлийн хуваарийн дагуу тайлагнасан гэсэн хариу ирүүлсэн.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тусгагдсан 28,221.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дэлгэрэнгүй бүртгэлд тусгаагүй. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлалын хавсралт дахь “*Гурав. Журналын бүртгэлийн бүтэц, зохион байгуулалт ...Бараа материал, авлага, үндсэн хөрөнгө, өглөг, цалин хөлс, зардлын тооцоотой холбогдсон дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, дэлгэрэнгүй бүртгэлийн товчоог бэлтгэнэ. Үүнд: ...5.Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл*” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

2.2 Эрсдэл:

Хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл дутуу байх, буруу бүртгэх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу тухай бүр бүрэн хөтөлж, бүртгэж байх.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Он дамжиж ирсэн 1,190,755.9 мянган төгрөгийн татаас, санхүүжилтийн авлагыг бүрэн барагдуулаагүй бусдад өгөх өглөгөөр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 45.2. дахь “*Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ*”, 43.3. дахь “*Төсвийн жил дуусахад Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан эргэлтийн сангийн үлдэгдэл хөрөнгийг төсөвт татан төвлөрүүлэх асуудлыг энэ хуулийн 18.6-д заасны дагуу шийдвэрлэх бөгөөд тухайн хөрөнгийг дараагийн жилийн батлагдсан төсвийн дагуу зарцуулна.*” заалтуудыг зөрчиж байна.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 21-д Сангийн сайдын төсвийн багцад батлагдан төсвийн жилд нь зарцуулаагүй үлдэгдэл төсвийг, Эрүүл Мэндийн яамнаас “Мед Монгол” ХХК-тай 262,546.8 мянган төгрөгийн, “Грийн химистри” ХХК-тай 36,800.0 мянган төгрөгийн, “Мед импекс интернэшнл” ХХК 642,642.0 мянган төгрөг, “Өнө тэгш арвижах” ХХК 248,767.2 мянган төгрөгийн тус тус тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх 5 багц ажлын гэрээ хийж нийт 1,190.756.0 мянган төгрөгийн өглөг үүсгэн тайлагнасан нь төсвийн дээрх заалт болон Төсвийн тухай хуулийн 6.4.8.”*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.*” заалтыг зөрчиж байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл:

3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. Заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгчийн зүгээс дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20 612 106 975.71</u>	<u>1 190 755 990.00</u>
АВЛАГА	1 529 863 958.87	1 190 755 990.00
Татаас, санхүүжилтийн авлага	1 529 863 958.87	1 190 755 990.00
УРЬДЧИЛГАА	19 082 243 016.84	0.00
Урьдчилж гарсан зардал	19 082 243 016.84	0.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26 418 890.17</u>	<u>110 374 973 700.07</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26 418 890.17	110 374 973 700.07
Биет хөрөнгө	21 918 890.17	110 371 973 700.07
Машин тоног төхөөрөмж (компьютер)	47 286 355.40	47 286 355.40
Хуримтлагдсан элэгдэл	(37 440 809.81)	(40 605 537.17)
Тавилга, аж ахуйн эд хогшил	12 968 999.00	12 968 999.00
Хуримтлагдсан элэгдэл	(5 822 321.14)	(7 704 212.26)
Бусад үндсэн хөрөнгө	8 000 000.00	8 000 000.00
Хуримтлагдсан элэгдэл	(5 333 333.28)	(8 000 000.00)
Дуусаагүй барилга, байгууламж	-	110 357 768 095.10
Ном	2 260 000.00	2 260 000.00
Биет бус хөрөнгө	4 500 000.00	3 000 000.00
Програм хангамж	10 415 000.00	10 415 000.00
Хуримтлагдсан элэгдэл	(5 915 000.00)	(7 415 000.00)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>20 638 525 865.88</u>	<u>111 565 729 690.07</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5 905 896.89</u>	<u>1 190 994 247.65</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5 905 896.89	1 190 994 247.65
Өглөг	5 905 896.89	1 190 994 247.65
Ажилчидтай холбогдсон өглөг	5 905 896.89	238 257.65
Бусад өглөг		1 190 755 990.00
Байгууллагад төлөх өглөг		1 190 755 990.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>20 632 619 968.99</u>	<u>110 374 735 442.42</u>
Засгийн газрын хувь оролцоо	20 632 619 968.99	110 374 735 442.42
Хуримтлагдсан үр дүн	20 632 619 968.99	110 374 735 442.42
Өмнөх үеийн үр дүн	19 268 188 881.63	87 656 339 197.58
Тайлант үеийн үр дүн	1 364 431 087.36	22 718 396 244.84
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>20 638 525 865.88</u>	<u>111 565 729 690.07</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	42 222 031 512.17	25 332 034 382.10
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40 334 275 341.80	23 698 334 382.10
Нийтлэг татварын бус орлого	40 334 275 341.80	23 698 334 382.10
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	40 334 275 341.80	22 721 941 890.80
Бусад орлого	-	976 392 491.30
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 887 756 170.37	1 633 700 000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	1 887 452 000.00	1 633 700 000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 887 452 000.00	1 633 700 000.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	304 170.37	-
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	304 170.37	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	40 857 600 424.81	2 613 638 137.26
УРСГАЛ ЗАРДАЛ	2 406 440 580.21	2 613 638 137.26
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 406 440 580.21	609 138 927.44
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408 350 840.98	-
Үндсэн цалин	12 071 921.72	-
Нэмэгдэл	394 079 527.46	-
Гэрээт ажлын хөлс	2 199 391.80	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46 812 929.34	53 405 467.28
Тэтгэврийн даатгал	46 812 929.34	53 405 467.28
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150 000.00	1 934 000.00
Байрны түрээс	150 000.00	1 934 000.00
Хангамж, бараа материалын зардал	10 078 522.55	16 699 592.42
Бичиг хэрэг	4 633 207.89	11 756 916.22
Тээвэр, шатахуун	3 400 588.36	2 750 000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 044 726.30	2 192 676.20
Томилолт, зочны зардал	1 294 000.00	-
Гадаад албан томилолт	414 000.00	-
Дотоод албан томилолт	880 000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45 522 873.10	527 886 582.54
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45 522 873.10	527 886 582.54
Бараа үйлчилгээний бусад зардал	1 894 231 414.24	9 213 285.20
Бараа үйлчилгээний бусад зардал	1 883 299 097.20	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10 932 317.04	9 213 285.20
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2 004 499 209.82
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2 004 499 209.82
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2 004 499 209.82
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38 451 159 844.60	-
Дотоод эх үүсвэрээр	38 451 159 844.60	-
Барилга байгууламж	15 383 498 063.80	-
Тоног төхөөрөмж	18 974 456 514.00	-
Бусад хөрөнгө	4 093 205 266.80	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1 364 431 087.36	22 718 396 244.84
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1 364 431 087.36	22 718 396 244.84

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	42 221 727 341.80	25 332 034 382.10
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40 334 275 341.80	23 698 334 382.10
Нийтлэг татварын бус орлого	40 334 275 341.80	23 698 334 382.10
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	40 334 275 341.80	22 721 941 890.80
Бусад орлого	-	976 392 491.30
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 887 452 000.00	1 633 700 000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	1 887 452 000.00	1 633 700 000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 887 452 000.00	1 633 700 000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3 902 793 007.26	2 940 228 166.30
УРСГАЛ ЗАРДАЛ	3 902 793 007.26	2 940 228 166.30
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 372 929 048.39	935 728 956.48
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	391 472 740.20	-
Нэмэгдэл	389 313 398.40	-
Гэрээт ажлын хөлс	2 159 341.80	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45 537 079.70	55 103 600.69
Тэтгэврийн даатгал	45 537 079.70	55 103 600.69
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150 000.00	1 934 000.00
Байрны түрээс	150 000.00	1 934 000.00
Хангамж, бараа материалын зардал	9 529 622.59	16 699 592.42
Бичиг хэрэг	4 080 481.29	11 756 916.22
Тээвэр, шатахуун	3 400 000.00	2 750 000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 049 141.30	2 192 676.20
Томилолт, зочны зардал	1 294 000.00	-
Дотоод албан томилолт	1 294 000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41 646 508.70	531 856 088.37
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41 646 508.70	531 856 088.37
Бараа үйлчилгээний бусад зардал	1 883 299 097.20	330 135 675.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1 883 299 097.20	330 135 675.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1 529 863 958.87	2 004 499 209.82
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1 529 863 958.87	2 004 499 209.82
Төвлөрүүлэх шилжүүлэг	1 529 863 958.87	2 004 499 209.82
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	38 318 934 334.54	22 391 806 215.80
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	38 451 159 844.60	22 391 806 215.80
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38 451 159 844.60	22 391 806 215.80
Дотоод эх үүсвэрээр	38 451 159 844.60	22 391 806 215.80
Барилга байгууламж	15 383 498 063.80	3 701 231 809.40
Тоног төхөөрөмж	18 974 456 514.00	18 690 574 406.40
Бусад хөрөнгө	4 093 205 266.80	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(38 451 159 844.60)	(22 391 806 215.80)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(132 225 510.06)	(0.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	132 225 510.06	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	19 268 188 881.63	19 268 188 881.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	19 268 188 881.63	19 268 188 881.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1 364 431 087.36	1 364 431 087.36
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	20 632 619 968.99	20 632 619 968.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	67 023 719 228.59	67 023 719 228.59
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	87 656 339 197.58	87 656 339 197.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	22 718 396 244.84	22 718 396 244.84
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	110 374 735 442.42	110 374 735 442.42

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,633,950,800.00	605,593,281.48	1,028,357,518.52	37.06
УРСГАЛ ЗАРДАЛ	1,633,950,800.00	605,593,281.48	1,028,357,518.52	37.06
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,633,950,800.00	605,593,281.48	1,028,357,518.52	37.06
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,299,400.00	55,103,600.69	4,195,799.31	92.92
Тэтгэврийн даатгал	59,299,400.00	55,103,600.69	4,195,799.31	92.92
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,285,000.00	1,934,000.00	1,351,000.00	58.87
Байрны түрээс	3,285,000.00	1,934,000.00	1,351,000.00	58.87
Хангамж, бараа материалын зардал	20,000,000.00	16,699,592.42	3,300,407.58	83.50
Бичиг хэрэг	12,000,000.00	11,756,916.22	243,083.78	97.97
Тээвэр, шатахуун	5,000,000.00	2,750,000.00	2,250,000.00	55.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,192,676.20	807,323.80	73.09
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	786,000,000.00	-	786,000,000.00	-
Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	-	30,000,000.00	-
Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	-	30,000,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	680,115,600.00	531,856,088.37	148,259,511.63	78.20
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	680,115,600.00	531,856,088.37	148,259,511.63	78.20
Бараа үйлчилгээний бусад зардал	841,250,800.00		841,250,800.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	841,250,800.00	330,135,675.00	511,115,125.00	39.24
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,633,700,000.00	605,593,281.18	1,028,106,718.82	37.07
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,633,700,000.00	605,593,281.18	1,028,106,718.82	37.07
Улсын төсвөөс санхүүжих	1,633,700,000.00	605,593,281.18	1,028,106,718.82	37.07
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	0.30	(0.30)	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	8	-	100.00
Удирдах ажилтан	1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	6	6	-	100.00
Үйлчлэх ажилтан	1	1	-	100.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020 он	Аудитын нэр: Үндэсний Оношилгоо, Эмчилгээний төв байгуулах /EDCF MON-08/ төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/707/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Үндэсний Оношилгоо, Эмчилгээний төв байгуулах /EDCF MON-08/ төслийн нэгж	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	НДШ-ын зардалд 53,405.5 мянган төгрөгийг тайлагнасан боловч Цалингийн зардлыг тайлагнаагүй.	53,405.5	Зөвлөмж өгсөн	Зохицуулагч Нягтлан бодогч	Ч.Бат-Эрдэнэ Ш.Дэлгэрмаа
2	НББ-ыг бүрэн үнэн зөв хөтлөөгүй.	28,221.1	Зөвлөмж өгсөн	Зохицуулагч Нягтлан бодогч	Ч.Бат-Эрдэнэ Ш.Дэлгэрмаа
3	1,190,755.9 мянган төгрөгийн авлага, 1,190,994.2 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." заалтыг зөрчиж байна.	1,190,755.99	Зөвлөмж өгсөн	Зохицуулагч Нягтлан бодогч	Ч.Бат-Эрдэнэ Ш.Дэлгэрмаа

